

АУДИТОР СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВАХ ТУХАЙ ЗАРЛАЛ

2025.05.20

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын “Аудитор”-ын албан тушаалын 1 сул орон тоог зарлаж байна.

Нэг. Албан тушаалд тавигдах шаардлага:

- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
- Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй
- Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч эсхүл төрийн жинхэнэ албаны нөөцөд байх
- Компьютерын өргөн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн
- Харилцааны болон багаар ажиллах ур чадвартай
- Ажлын ачаалал даах чадвартай
- Эерэг хандлага, чин сэтгэлтэй
- Судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байсан, түүндээ үнэлэлт, дүгнэлт өгч байсан бол давуу тал болно.

Хоёр. Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Төрийн албан хаагчийн анкет
- Иргэний үнэмлэхийн хуулбар /E-mongolia лавлагаа/
- Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт /хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;
- Шаардлагатай бол мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт;
- Иргэн болон Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүйг нотлох бичиг баримт/e-mongolia-Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай/
- Төрийн жинхэнэ албан хаагч бол сүүлийн 1 жилийн дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүйг нотлох бичиг баримт
- “4 х 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх:

Албан тушаалын орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцох албан хаагч, иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг 2025 оны 06 дугаар сарын 3-ны

өдрийн 17:00 цаг хүртэл Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 01 тоотод хүлээн авна.

Дөрөв: Хүсэлт ирүүлсэн албан хаагчдад мэдээлэл хүргэх:

Орон тоо нөхөх тусгай шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн албан хаагч, иргэний бичиг баримтыг хянаж, албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэхийг ирүүлсэн бичиг баримтаар болон ярилцлагаар шалгаруулж, шаардлага хангасан албан хаагч, иргэнд тусгай шалгалтыг зохион байгуулах хугацааг цахим хаягаар мэдэгдэнэ.

Хаяг: Нутгийн удирдлагын ордны 4 давхар 1 тоот өрөө

Цахим шуудангийн хаяг: dornod@audit.gov.mn

Холбогдох утас: 7058-4204, 7058-4207, 9993-2901

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

